



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 03 өдөр

Дугаар 415

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө дуудлагын худалдаагаар  
худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Татварын ерөнхий газрын харьяа зарим Татварын хэлтсүүдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, нийт 243,495,535.98 (хоёр зуун дөчин гурван сая дөрвөн зуун ерэн таван мянга таван зуун гучин таван төгрөг ерэн найман мөнгө) төгрөгийн балансын үнэ, 217,032,112.06 (хоёр зуун арван долоон сая гучин хоёр мянга нэг зуун арван хоёр төгрөг зургаан мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан 9 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Татварын ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Занданбатад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.4.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА



Боловсруулсан: .....  
0002265



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
2018 оны 10 дугаар сарын ...-ний өдрийн  
415 дугаар тогтоолын хавсралт

Татварын ерөнхий газрын харьяа зарим Татварын хэлтсүүдийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах автомашины жагсаалт

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Гүйлт, км	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	Сэргээгч босголт (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)	Дэнчингийн хэмжээ (төгрөг)	Эзэмшигч байгууллагын нэрс
1	Ландкрийзер-80, 80-80 ДУА, арал № FZJ800094412	1996/2011	242,2	37,000,000.00	37,000,000.00	0	0	1,500,000.00	375,000.00	Дундговь аймгийн Татварын хэлтэс
2	Рэнаултсамсунг, 95-78 УБЗ, арал № КНМС4С2НМАРС52455	2010/2010	75,7	27,360,000.00	27,360,000.00	0	0	1,000,000.00	250,000.00	Баянгол дүүргийн Татварын хэлтэс
3	Старех, 37-63 УБН арал № КМЈWВWН7НР5U653327	2005/2006	120,1	24,753,750.00	24,753,750.00	0	0	500,000.00	125,000.00	Баянгол дүүргийн Татварын хэлтэс
4	Рэнаултсамсунг, 02-31 УНД, арал № КНМС4С2НМАРО35062	2001/2010	74,0	27,360,000.00	27,360,000.00	0	0	1,000,000.00	250,000.00	Сүхбаатар дүүргийн Татварын хэлтэс
5	Рэнаултсамсунг, 89-48 УНА, арал № КНМС4С2НМАРО52876	2001/2010	69,0	27,360,000.00	17,624,585.02	9,735,414.98	0	9,750,000.00	2,437,500.00	Баянзүрх дүүргийн Татварын хэлтэс

6	Блуебирд, 30-28 ДАХ, арал№ FG10131091	2004/ 2013	205,0	9,900,000.00	7,557,598.96	2,342,401.04	0	2,350,000.00	587,500.00	Дархан-Уул аймгийн Татварын хэлтэс
7	Харриер, 37-52 ДАХ, арал№ АСУ300006900	2003/ 2014	229,1	25,000,000.00	10,614,392.10	14,385,607.90	0	14,400,000.00	3,600,000.00	Дархан-Уул аймгийн Татварын хэлтэс
8	Прадо, 78-90 ӨМА, арал№ RZJ95000035532	2000/ 2008	124,5	21,869,000.00	21,869,000.00	0	0	1,000,000.00	375,000.00	Өмнөговь аймгийн Татварын хэлтэс
9	Навара, УВХ, арал№ MNTCCUD4070016979	2012/ 2012	180,1	42,892,785.98	42,892,785.98	0	0	1,000,000.00	250,000.00	Увс аймгийн Татварын хэлтэс
	Нийт дүн			243,495,535.98 (хоёр зуун дөчин гурван сая дөрвөн зуун ерэн таван мянга таван зуун гучин таван төгрөг ерэн найман мөнгө)	217,032,112.06 (хоёр зуун арван долоон сая гучин хоёр мянга нэг зуун арван хоёр төгрөг зургаан мөнгө)	26,463,423.92 (хорин зургаан сая дөрвөн зуун жаран гурван мянга дөрвөн зуун хорин гурван төгрөг ерэн хоёр мөнгө)		32,500,000.00 (гучин хоёр сая таван зуун мянган)		